



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2017

Э-сонин

7-Р САР

52-р дугаар






Зах зээлийн тойм


/2017.07.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	16
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	63,416,980,218
Хувьцаа	1,736,671,733
Засгийн газрын үнэт цаас /анхдагч/	50,398,364,475
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	11,281,944,010
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	2,646,248
Хувьцаа	2,007,262
Засгийн газрын үнэт цаас /анхдагч/	521,099
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	117,887
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	1,810


Зах зээлийн үнэлгээ



MSE ALL индекс



TOP-20 индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	220
100% төрийн өмчит	19
Төрийн өмчийн оролцоотой	12
Хувийн өмчийн	189
I ангилал	7
II ангилал	45
III ангилал	167
Ангилалдаагүй	1

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	58
Брокер, Дилер	58
Андеррайтер	24
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

/2017.07.31-ний байдлаар/

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/
		Тоо ширхэг	Үнийн дүн	Тоо ширхэг	Үнийн дүн	
1	Голомт Капитал ХХК	199,742	75,002,814.90	747,287	311,459,563.10	386,462,378.00
2	БиДиСек ХК	492,062	223,082,855.70	316,845	112,888,505.80	335,971,361.50
3	Стандарт инвестмент ХХК	133,600	134,569,595.30	114,235	35,331,690.90	169,901,286.20
4	Ти Ди Би Капитал ХХК	186,441	75,422,185.20	130,698	39,018,015.00	114,440,200.20
5	Ард секюритиз ХХК	188,132	82,900,347.40	76,473	17,144,287.00	100,044,634.40
6	Бумбат-Алтай ХХК	130,091	78,083,037.00	29,587	20,517,965.00	98,601,002.00
7	Блүмсбюри секюритиес ХХК	50,217	33,755,138.00	37,251	63,856,501.00	97,611,639.00
8	Ард капитал групп ХХК	128,841	47,079,611.60	46,704	24,384,833.50	71,464,445.10
9	Тэсо Инвестмент	55,073	24,893,190.00	86,083	39,215,969.00	64,109,159.00
10	Эм Ай Си Си ХХК	2,148	4,467,880.00	11,204	55,491,460.00	59,959,340.00
11	Новел инвестмент ХХК	134,545	51,533,540.00	10,334	5,383,240.00	56,916,780.00
12	Зэргэд ХХК	21,319	10,262,840.00	103,714	41,236,194.40	51,499,034.40
13	Гаули ХХК	99,722	21,367,566.60	84,027	29,983,930.00	51,351,496.60
14	Өндөрхаан инвест ХХК	59,187	22,482,009.00	64,074	26,876,342.00	49,358,351.00
15	Булган брокер ХХК	5,380	1,923,168.00	6,728	34,985,600.00	36,908,768.00
16	Евразиа капитал монголиа ХХК	36,441	26,362,755.00	5,951	2,503,094.79	28,865,849.79
17	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	53	699,600.00	2,961	21,494,800.00	22,194,400.00
18	Таван богд ХХК	0	0.00	2,645	21,869,264.00	21,869,264.00
19	Тулгат чандмань баян ХХК	88	200,952.00	59,704	18,623,670.00	18,824,622.00
20	СИКАП	19,998	7,799,220.00	24,878	9,702,420.00	17,501,640.00

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2017.07.31-ний байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд	Доод	Хаалт	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт /%/
1	APU	АПУ	1,337,731	521,906,201.40	435.00	295.00	386.66	96.63	33.32
2	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	192,915	12,268,036.50	75.00	60.00	70.00	6.07	9.49
3	SUU	СҮҮ	145,309	19,853,504.00	145.00	132.00	137.42	0.35	0.26
4	RMC	РЕМИКОН	67,880	3,069,561.60	48.00	40.00	44.98	-0.28	-0.62
5	MRX	МЕРЕКС	51,931	2,798,137.00	55.00	50.00	51.70	-1.85	-3.45
6	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	41,568	16,129,912.00	390.00	383.00	383.00	-5.00	-1.29
7	TTL	ТАВАН ТОЛГОЙ	38,721	197,436,810.00	5,600.00	4,750.00	5,350.00	555.00	11.57
8	HGN	ХӨХ ГАН	26,338	2,803,489.20	115.00	80.00	82.66	-17.24	-17.26
9	ETR	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	12,845	1,398,435.00	109.00	108.00	108.87	-6.06	-5.27
10	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	9,569	5,219,561.00	570.00	481.00	491.00	-13.25	-2.63
11	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	8,742	4,151,844.00	500.00	469.00	471.00	-24.00	-4.85
12	MIB	МОНИНЖБАР	8,107	1,454,220.00	183.00	158.00	158.00	-27.00	-14.59
13	JLT	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	7,577	1,996,558.79	312.00	224.80	312.00	116.50	59.59
14	MMX	МАХИМПЕКС	6,381	15,320,990.00	2,497.00	2,350.00	2,449.00	49.00	2.04
15	MDR	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	5,490	2,060,190.00	390.00	375.00	375.05	-14.95	-3.83
16	HBO	ХАЙ БИ ОЙЛ	5,351	532,699.50	100.00	98.10	100.00	0.00	0.00
17	OLL	ОЛЛОО	5,350	401,250.00	75.00	75.00	75.00	-11.20	-12.99
18	SHV	ШИВЭЭ ОВОО	4,250	8,781,155.00	2,250.00	2,000.00	2,040.00	-450.00	-18.07
19	GOV	ГОВЬ	3,786	51,951,490.00	15,350.00	13,110.00	13,910.00	860.00	6.59
20	SHG	ШАРЫН ГОЛ	3,578	7,610,565.00	2,200.00	2,005.00	2,136.00	-164.00	-7.13



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2017.07.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /төгрөг/	Өөрчлөлт /%/
			2017-7-03	2017-07-31		
1	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	7577	195.5	312	116.5	59.59
2	ХИШИГ УУЛ	376	1021	1400	379	37.12
3	СОР	13	860	1130	270	31.40
4	АПУ	1337731	295	386.66	91.66	31.07
5	ТАВИЛГА	50	1000	1200	200	20.00
6	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	4	56.22	64.65	8.43	14.99
7	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	59	2324	2672	348	14.97
8	ЖЕНКО ТУР БЮРО	192915	60.9	70	9.1	14.94
9	ДАРХАН ХҮНС	10	4370	5020	650	14.87
10	УЛААНБААТАР ХИВС	6	12490	14250	1760	14.09
11	БАГАНУУР	2212	1701	1920	219	12.87
12	АВТО ИМПЕКС	89	2131	2400	269	12.62
13	ИХ БАРИЛГА	20	2500	2799	299	11.96
14	ТАВАН ТОЛГОЙ	38721	4784	5350	566	11.83
15	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	112	44080	48000	3920	8.89
16	АРИГ ГАЛ	222	2451	2650	199	8.12
17	УБ-БҮК	160	397.77	425	27.23	6.85
18	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	628	36060	38000	1940	5.38
19	ГАН ХИЙЦ	6	13800	14500	700	5.07
20	ДАРХАН НЭХИЙ	154	20500	21500	1000	4.88

Ханшийн бууралттай хувьцаа

/2017.07.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт Төгрөг/	Өөрчлөлт
			2017-7-03	2017-07-31		
1	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	343	500	390.22	-109.78	-21.96
2	ХАР ТАРВАГАТАЙ	30	9900	7800	-2100	-21.21
3	МОНГОЛ ШЕВРО	63	1520	1200	-320	-21.05
4	ГОНИР	1500	170	140	-30	-17.65
5	НАКО ТҮЛШ	1303	165.82	137	-28.82	-17.38
6	ХӨХ ГАН	26338	99.9	82.66	-17.24	-17.26
7	МОНГОЛ НЭХМЭЛ	273	4400	3740	-660	-15.00
8	ХЭРЛЭН ХИВС	400	94	80	-14	-14.89
9	БИ ДИ СЕК	125	1161	990	-171	-14.73
10	МОНИНЖБАР	8107	185	158	-27	-14.59
11	ОЛЛЮО	5350	86.2	75	-11.2	-12.99
12	БӨХӨГ	9	5070	4500	-570	-11.24
13	СТАНДАРТ НООС	409	449	400	-49	-10.91
14	МОГОЙН ГОЛ	82	5600	5150	-450	-8.04
15	ТАХЬ-КО	50	19490	18000	-1490	-7.64



“СҮҮ БОНД”-ЫН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ НЭЭЛЭЭ

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Сүү" ХК-ийн гаргасан нийт 60,000 ширхэг “Сүү бонд”-ын анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж, бүртгэгдсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 06 сарын 30-ний 1/2064 албан тоотыг үндэслэн "Сүү бонд"-ын хоёрдогч зах зээлийн арилжааг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс нээлээ. Үүнтэй холбогдуулан тус өрийн хэрэгслийг хоёрдогч зах зээл дээрээс хүссэн үедээ худалдан авах, эргүүлэн худалдах боломжтой болж байгаа юм.

"АПУ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"АПУ" ХК нь 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн №17/23 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлалаа

Хугацаа: 2017 оны 08 сарын 18-ны 14:00 цагт

Хуралдах газрын хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүргийн Соёлын ордон

Бүртгэх өдөр: 2017-07-25

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах, шинээр охин компани үүсгэн байгуулахыг зөвшөөрөх тухай;
2. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрөх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл, нэгтгэх гэрээг батлах тухай;
3. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай;
4. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай;
5. АПУ ХК-ийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай;

ЗГҮЦ-НЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА ӨРСӨЛДӨӨНТ ХЭЛБЭРЭЭР ЯВАГДЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК дээр арилжигдаж буй Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ны анхдагч зах зээлийн арилжааг 2010-2011 онд өрсөлдөөнт буюу үнэт цаасны хүүгийн хувь хэмжээг дуудлага арилжаанд үндэслэн тогтоох хэлбэрээр, 2014 оноос эхлэн зөвхөн өрсөлдөөнт бус буюу ЗГҮЦ-ны хүүгийн хувь хэмжээг зах зээлийн жишиг хүүгийн түвшинд үндэслэн тогтоох хэлбэрээр явуулж байсан билээ.

2017 оны 7 дугаар сараас Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд дуудлага арилжаа буюу өрсөлдөөнт арилжааны хэлбэрийг нэмэх болсонтой холбогдуулан “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 7-р сарын 04-ний өдрийн А/115 тоот тушаалаар “Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах заавар”-ыг шинэчлэн баталж, 2017 оны 7 дугаар сарын 5 -ны өдөр ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааг өрсөлдөөнт хэлбэрээр амжилттай явууллаа.

2017 оны 7 дугаар сард зохион байгуулагдсан нийт 3 удаагийн өрсөлдөөнт арилжаагаар 9,3 тэрбум төгрөгийн үнэт цаас амжилттай арилжаалагдсанаар Сангийн яамнаас үнэт цаасанд төлөх хүүгийн төлбөр, Улсын төсөвт тусгагдах үнэт цаасны хүүгийн зардал 84 сая төгрөгөөр буурсан байна.



"ТОП-20" ИНДЕКСИЙН САГС ШИНЭЧЛЭГДЛЭЭ

Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам”-ын 2-р зүйлийг үндэслэн ТОП-20 индексийн багцыг 2017 оны сүүлийн хагас жилд бүрдүүлэх үнэт цаасуудыг дараах байдлаар сонгон шалгаруулав.

2017 оны эхний хагас жилийн үзүүлэлтээр ТОП-20 индексийн сагсыг шинэчлэхэд өмнөх сагсад багтаж байсан 16 компани хэвээр үлдэж, “УБ-БҮК”, “Гермес центр”, “Мерекс”, “Ремикон” ХК-иуд хасагдаж, шинээр “Бидисек”, “Гутал”, “Женко тур бюро”, “Монголын цахилгаан холбоо” ХК-иуд нэмэгдэн шинэчилсэн сагсыг бүрдүүлж байна.

№	Сим бол	Үнэт цаасны нр	Зах зээлийн үнэлгээ / төгрөг/	Арилжааны орсон өдөр /125 өдөр/	Өдрийн дундаж гүйлгээ / төгрөг/
1	TTL	ТАВАН ТОЛГОЙ	123,739,290,500	119	15,930,820
2	GOV	ГОВЬ	101,804,681,250	121	5,037,922
3	APU	АПУ	215,456,616,310	121	4,593,559
4	TCK	ТАЛХ ЧИХЭР	22,214,355,100	84	2,017,922
5	NEH	ДАРХАН НЭХИЙ	22,662,319,500	67	837,430
6	SUU	СҮҮ	47,152,080,000	111	796,819
7	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	15,255,723,900	54	3,264,886
8	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	13,137,432,844	99	5,574,109
9	MIE	МАТЕРИАЛИМПЕКС	10,945,648,000	43	608,380
10	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	18,219,885,750	92	477,713
11	HGN	ХӨХ ГАН	10,121,623,944	55	4,607,349
12	GTL	ГУТАЛ	27,533,814,840	30	379,979
13	BDS	БИ ДИ СЕК	20,230,000,000	35	359,594
14	MMX	МАХИМПЕКС	9,121,730,400	85	1,260,091
15	EER	АРИГ ГАЛ	8,527,813,320	65	1,150,986
16	BAN	БАГАНУУР	9,417,487,640	69	348,861
17	ADL	АДУУН ЧУЛУУН	6,620,889,704	78	693,503
18	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	6,393,000,000	93	6,767,794
19	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	5,913,174,356	56	1,017,594
20	SHG	ШАРЫН ГОЛ	23,391,556,600	50	249,925

СЗХ-НООС ЗӨВШӨӨРӨГДСӨН ХӨРӨНГИЙН БИРЖҮҮДИЙН ТҮР ЖАГСААЛТЫГ БАТАЛЛАА

2013 оны 5 дугаар сарын 24-ны өдөр “Үнэт цаасны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга батлагдаж, мөрдөгдөж эхэлснээр гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд Монгол Улсад, Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд олон улсад давхар бүртгэл хийлгэх замаар хувьцаагаа арилжаалах эрх зүйн орчин нээлттэй болсон билээ.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь энэхүү эрх зүйн боломжийг бодит ажил хэрэг болгохоор зах зээлийн зохицуулагч болон оролцогч байгууллагуудтай хамтран ажиллаж, холбогдох дүрэм, журмуудад шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах ажлуудыг эхлүүлээд байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 7-р сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 18 дугаар зүйлийн 18.4 дэх заалтуудын дагуу Монголын хөрөнгийн биржийн саналыг үндэслэн **"Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаадын үнэт цаас гаргагчийн бүртгүүлсэн арилжаа эрхлэх байгууллагын түр жагсаалт"** болон **"Монгол Улсын хадгаламжийн бичгийн суурь үнэт цаасны бүртгэл бүхий харьяалах улсын түр жагсаалт"**-ыг тус тус батлан гаргасан байна.

Энэхүү шийдвэр нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах сайн тогтолцоо бүхий 26 хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн хувьцаа, 24 улсад бүртгэлтэй үнэт цаасанд суурилсан хадгаламжийн бичгийг Монголын хөрөнгийн зах зээлд арилжихад дотоодод мөрдөгдөж буй холбогдох дүрэм, журмын шалгуур, шаардлагаас хөнгөлөх, чөлөөлөх боломжийг бүрдүүлэх юм. Ингэснээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг, гадаадын нэр бүхий 5 хөрөнгийн биржид хувьцаа нь арилжаалагдаж буй 30 гаруй компанийн үнэт цаасыг дотоодын хөрөнгийн биржээр арилжаалахын зэрэгцээ ард иргэд эдгээр компаниудын хувьцааг эзэмшиж, ашиг шимийг нь хүртэх боломж илүү ойртож байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN